

20 ²⁴ оны ¹⁰ сарын ¹⁵ -ны өдөр

№ ²⁴

Улаанбаатар хот

Зээл авах их хэмжээний хэлцэл байгуулахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компани нь гадаадын хөрөнгө оруулалт татах зорилгоор 10,000,000 (арван сая) ам.долларын зээлийг 36 (гучин зургаа) сарын хугацаатай, жилийн 13 (арван гурав) хувийн хүүтэй зээл авах зөвшөөрөл олгож, холбогдох их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Зээлийн үүргийн гүйцэтгэлийн хангах зорилгоор Зээлдэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд заасан компанийн зээлийн багцыг барьцаалахыг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хөрөнгө оруулалт татах зорилгоор холбогдох этгээдүүдтэй гэрээ, хэлцлийг байгуулах, түүнтэй холбоотой баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, Санхүү хариуцсан захирал /Б.Батжаргал/ нарт олгосугай.
4. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж ажиллахыг Эрсдэл хяналт шалгалт хариуцсан захирал /Д.Баярбат/, Санхүү хариуцсан захирал /Б.Батжаргал/ нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

